

Д.Дэлгэрсайхан: Богино хугацаан дахь ханшийн хэлбэлзэл шатахууны үнийн огцом өсөлтийн шалтгаан болоогүй

Валютын ханш, шатахууны үнийн өсөлтийг тойрсон асуудлаар Монголбанкны Валют, эдийн засгийн газрын захирал Д.Дэлгэрсайхантай ярилцлаа.

Шинэ оны эхэнд шатахууны үнэ огцом өслөө. Үүний шалтгааныг зарим хүмүүс валютын ханшнаас болсон гэж тайлбарлаж байна. Төгрөгийн валюттай харьцах ханш суларсан нь шатахууны үнэ өсөх шалтгаан болсон уу?

Гол шалтгаан нь валютын ханшийн чангаралт бус гадаад зах зээл дэх нефтийн бүтээгдэхүүний үнэ өссөнд байгаа юм. Өөрөөр хэлбэл төгрөгийн валюттай харьцах ханшийн сулралт нь шатахууны үнийг литр тутамд нь 235-260 төгрөгөөр буюу дунджаар 16 хувиар огцом өсөх шалтгаан болоогүй. Үүнийг нотлох хэд хэдэн баримт хэлье. Судалгаанаас үзэхэд 2010 оны эхнээс өнөөг хүртэлх хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3 хувиар чангарсан байхад дотоодын зах зээлд АИ92 маркийн шатахууны үнэ 33 хувиар өссөн байх юм. Төгрөгийн ханш хоёр жилийн өмнөх түвшиндээ байхад түлш шатахууны үнэ нь шатахууны төрлөөсөө хамаараад хоёр жилийн өмнөхөөс 33-47 хувиар өсчихөөд байна. Харьцангуй богино хугацааг хамруулан зарим нэг энгийн тооцоо хийгээд үзье. Шатахууны бизнес дунджаар 14 хоногийн мөчлөгтэй байдаг гэсэн тооцоо бий. Өөрөөр хэлбэл импортлосон шатахуунаа борлуулж дуусах, дахин импортоор авч борлуулах дундаж хугацаа 14 хоног гэсэн үг. Шатахууны үнэ огцом 16 хувиар өссөн мөчлөгт харгалзах хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханшид 2 хувийн л өөрчлөлт гарсан. Иймд богино хугацаан дахь ханшийн хэлбэлзэл шатахууны үнийн огцом өсөлтийн шалтгаан болоогүй гэдэг нь тодорхой байгаа юм.

Шатахууны үнийн өсөлт гадаад зах зээлийн шалтгаантай юм бол яагаад валютын ханшийн өсөлтөөс болсон, Монголбанк хангалттай нөөцтэй байж доллар зараагүйгээс болсон гэж олон нийтийн дунд яриа үүсээд байгаа юм бэ?

Монголбанк валют нийлүүлээгүйгээс болсон гэсэн олон нийтийн дунд үүсээд байгаа ташаа ойлголт бол шатахууны үнэ өссөн бодит шалтгааныг нийгэмд зөв тайлбарлаагүйтэй холбоотой. Энэ мэт ташаа мэдээлэл олон нийтэд тараах нь ханшийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг. Валютын ханш нь ерөнхийдөө эдийн засгийн суурь нөхцөлөөр тодорхойлогдох боловч богино хугацааны ханшийн хэлбэлзэлд зах зээлд оролцогчдын авч буй мэдээлэл, хүлээлт ихээр нөлөөлдөг. Сүүлийн хэд хоногт шатахууныг тойрсон асуудал даамжирсаар бүр төрийн мөнгөний бодлогыг улс төржүүлэх, хараат бус байдалд нь сөргөөр нөлөөлж болзошгүй зохисгүй үйлдлүүд ч ажиглагдах болсон. Нөгөө талаар, Монголбанк хангалттай нөөцтэй байгаа гэсэн яриа гараад байгаа. Бид 2008 онд валютын нөөц түүхэндээ анх удаа 1 тэрбум ам.долларт хүрэхэд хангалттай нөөцтэй гэж энэ мэт ойлгож байсан цаг саяхан. Хямралтай нүүр тулахад тэр нь хангалттай байж чадаагүй шүү дээ. Тэр цагаас хойш импорт жилийн дүнгээрээ 2 илүү дахин өсчихөөд байхад бид одоо 2.2 тэрбум ам.долларын нөөцтэй сууж байна шүү дээ. Үүнийг хангалттай гэж ярьж болохгүй нь хэнд ч ойлгомжтой. Ялангуяа, дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байгаа өнөө үед. Бид ер нь асуудалд ул суурьтай хандах хэрэгтэй. Ташаа мэдээлэлд үндэслэн аливаа шийдвэр гаргах бодлогын түвшиндээ ч, иргэд, аж ахуйн нэгжийн хувьд ч эрсдэлтэй гэдгийг энд сануулмаар байгаа юм.

Монголбанкнаас ханшийн талаар ямар бодлого баримталдаг юм бэ?

Монгол улс төгрөгийн валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж уян хатан тогтож байх маш тодорхой зарчмыг сүүлийн жилүүдэд баримталсаар ирсэн. Цаашид ч уг зарчмыг

тууштай баримтална. Валютын захад богино хугацааны эрэлт, нийлүүлэлтийн хэт их зөрүү үүсч, тэр нь ханшийг огцом хэлбэлзүүлэх тохиолдолд Монголбанк тэрхүү огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор валютын захад оролцож зохицуулдаг. Бид ханшийн түвшинг зорилт болгон барьдаггүй, зөвхөн ханшийн огцом хэлбэлзэлтэй л тэмцдэг. Энэ ч зорилгоор Монголбанк өнгөрсөн оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн валютын захад оролцож, богино хугацааны эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг зохицуулсан. Энэ хугацаанд нийт 300 гаруй сая ам.долларыг захад нийлүүлж, ханшийн огцом савлагаа үүсэхээс сэргийллээ. Өнгөрсөн хэд хоногт нийгмийн сэтгэлзүйд гарсан үймээн нь валютын дотоодын захад сөргөөр нөлөөлсөн. Ийм үед Монголбанк авах ёстой арга хэмжээгээ тасралтгүй хэрэгжүүлж, нийгэмд үнэн бодитой мэдээллийг өгсний үр дүнд ханш тогтворжоод байна.

Төгрөгийн ханш валютын эсрэг суларсан нь юутай холбоотой байна вэ?

2011 оны статистикаас дурдахад, Төлбөрийн урсгал тэнцэл, тэр дотроо гадаад худалдааны алдагдал 1.7 тэрбум ам.долларт хүрчихээд байна. Үүнтэй уялдан валютын цэвэр урсгал ч буурч байна. Иймээс макро эдийн засгийн суурь нөхцөл өөрөө төгрөгийн валюттай харьцах ханш өнгөрсөн оны сүүлийн хагасаас эхлэн суларсны үндсэн шалтгаан нь болж байна.

Валютын ханшийн өөрчлөлтийг хэрхэн удирдах нь зүйтэй вэ?

Ханшийн эрсдлийг удирдахыг тулд эрсдлийг бууруулах санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг ашиглах хэрэгтэй байна. Деривативын зах зээлийн гол зорилго нь ч эрсдлийг удирдахад оршдог. Монголбанк сүүлийн жил хагасын хугацаанд төгрөг ам.долларын, төгрөг юанийн своп хэлцлүүд хийх бүхий л боломжийг бүрдүүлж, банкууд, хувийн хэвшлийнхэнд удаа дараа сургалт зохион байгуулах, тэдэнд ач холбогдлыг нь ойлгуулах, бодитой хэлцлүүд хийх замаар валютын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зэрэг арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлсэн. Хэрэглээ талдаа учир дутагдалтай байна. Зүй нь эдгээр хэрэгслүүдээ идэвхтэй ашиглах ёстой бөгөөд ингэснээр ханшийн эрсдэлийг нийт системийн хэмжээнд бууруулах бололцоотой юм.

Т.ЖИГУҮР